



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/640

Ховд

Төсөл сонгон шалгаруулалт зохион  
байгуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 9/05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын нутаг дэвсгэрт нийт 0.6 га газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2019 оны 12 дугаар сарын 09 -ний өдөр зохион байгуулж явуулсугай.

2. Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг хавсралтаар баталсугай.


3. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох материалыг хуулийн дагуу бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 08 –ны өдрийн А/640 дугаар  
захирамжийн хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ  
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Бугат баг

д/д	Байршил	Эзэмших хугацаа	Хэмжээ /га/	Зориулалт
1	Шинэ суурьшлын бүс	15	0,6	Хаус хороолол

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг  
явуулах тухай

Нэг: Төсөл сонгон шалгаруулах тухай үндсэн мэдээлэл

1.1 Газрын тухай хууль, Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, , 2019 оны 06 дүгээр сарын 17-ны 9/05 дугаар тогтоолоор тус тус баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зарим заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу дараах газрыг төсөл сонгон шалгаруулалтын журмаар шийдвэрлэх.

Хоёр. Төсөл сонгон шалгаруулалтад оролцох сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дор дурдсан ерөнхий нөхцөл, шаардлага хангасан байвал зохино.

2.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1 Хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх;

2.1.2 Мэргэжлийн ажиллах хүчний болон техник технологи, тоног төхөөрөмжийн чадавх, нөөцтэй байх;

2.1.3 Төсөл нь зарласан нөхцөл шаардлага, стандартыг хангасан байх;

2.1.4 Төслөө зарласан хугацаанд ирүүлсэн байх;

2.1.5 Шаардлагатай тохиолдолд холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байх.

2.2 Төслийг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр шалгаруулна.

2.2.1 Төсөл нь зард тусгасан шаардлага болон бүрдлийг хангасан эсэх;

2.2.2 Барилга, хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагад нийцсэн эсэх;

2.2.3 Төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулсан эсэх;

2.2.4 Төсөл нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулагдсан бизнес төлөвлөгөөтэй эсэх;

2.2.5 Төсөл нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын болон чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаж түүнд нийцсэн эсэх;

2.2.6 Төсөл хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны тоо, хэмжээ;

2.2.7 Тухайн хот, тосгон, суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжилд ач холбогдолтой эсэх;

2.2.8 Улс, орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ;

2.2.9 Тухайн газарт явуулах үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх.

2.3 Оролцогчид нь төслөө битүүмжилж аймгийн ГХБХБГ газарт өөрөө өгөх буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүргүүлэх, хэрэв ийнхүү хүргэх боломжгүй бол зар мэдээнд заасан хугацаанд шуудангаар ирүүлж болно.

2.18 Оролцогч нь хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвар болон төсөл шалгаруулалтад ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

2.19 Шалгарсан иргэн, ААН гэрээ байгуулснаас хойш нэг жил /365/ хоногийн дотор төслийн ажлаа эхлүүлээгүй тохиолдолд гэрээг үл маргах журмаар цуцална.

2.20 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамж төлнө./12500төг/


2.21 Шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх болон төслийг ирүүлэх эцсийн хугацаа

Материалыг 2019 оны 10 сарын 08-ээс 12 сарын 06 -ны өдрийн 17<sup>00</sup> цаг хүртэл авна.

Холбогдох мэдээллийг доорхи утаснуудаас лавлана уу?

Харилцах утас 70434019, 99201484, 89099968

Гурав. Эзэмшүүлэх газрын байршил, хил заагийг харуулсан тойм зураг, схем Үүнд: Байршил 1. Бугат баг Шинэ суурьшлын бүсэд Хаус хороололын зориулалтаар 0,6 га газар



Шалгуур үзүүлэлт :

- а. Барилгын төрөл давхрын тоо – 1-2 давхар
- б. Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө – 15 га-гийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
- в.Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага - БНБД-ийн дагуу хийнэ.
- г. Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл - Хотын ерөнхий төлөвлөгөөг мөрдөнө.  
- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дагаж мөрдөнө
- д. Инженерийн бэлтгэл арга хэмжээ /үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ/ - Өндөржилттэй уялдуулан үерийн болон борооны усны зайлуулах арга хэмжээ авах
- е.Цахилгаан, цэвэр, бохир усны хангамжийг техникийн нөхцлийн дагуу
- ё. Дулаан – Ховд дулааны станц ТӨК хангана.
- Ж. Холбоо дохиоллыг шинээр олгох техникийн нөхцлийн дагуу

-oOo-